



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/16

Онги

Хөрөнгө зарцуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоол, Байгаль хамгаалах сангийн зарцуулалтыг батлах тухай Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 68 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан-Овоо сумын Онги багийн нутаг Цогт уул, Ахар уул агнуурын бүс нутагт нутагшин амьдарч байгаа Аргал, Янгирт хужир, өвс тавьж биотехникийн арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Тунгалаг), Онги багийн засаг дарга (Г.Пүрэв), "Бор бавдай" нөхөрлөлийн гишүүдэд даалгасугай.

2. Хужир татаж өвс тавих шатахууны зардалд 206,450 (хоёр зуун зургаан мянга дөрвөн зуун тавин) төгрөг, 45 боодол өвсний үнэ болох 315,000 (Гурван зуун арван таван мянган) төгрөг, нийт биотехникийн арга хэмжээ авахад зарцуулагдах 521,450 (Таван зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун тавин) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах сангаас гаргахыг нягтлан бодогч (Г.Чагдарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМАРСАНАА